

Түүх 7: Иошуа

Библийн эшлэл
[Иошуа 6:20а]

Тийнхүү ард олон уухайлан хашхирч, тахилч нар бүрээнүүдээ үлээв. Хүмүүс бүрээн дууг сонсоод маш чангаар уухайлсанд хана доошоо нуран унаж,

Израиль ард түмний удирдаж байсан Мосе Канаан нутагт орохын өмнө нас барсан учир Бурхан шинэ удирдагчаар Иошуаг томилжээ. Бурхан Иошуад “Би чамтай үргэлж хамт байх болно” гэж хэлжээ.

Ингээд Иошуа Иерихо хот уруу хоёр тагнуулчаа явуулав.

Тэр хоёр хот уруу ороод Рахаб гэгч эмэгтэйн гэрт байрлахдаа, тэр хотын тухай олон зүйлийг мэдэж авчээ.

Израилийн тагнуулчид Иерихо хотод ирсэн гэдгийг мэдсэн хаан маш их уурлаж, тэднийг барихыг тушаажээ.

Тэр үед Рахаб тагнуулчдыг зугтахад нь туслав.

Рахаб тэдэнд ингэж хэлэв. Би та нарт тусалсан шиг та нар энэ хотыг эзлэхээр ирэхдээ намайг болон гэр бүлийг минь амьд үлдээгээрэй гэв.

Тагнуулчид Рахабт амлалт өгч Иерихо хотоос эсэн мэнд аюулгүйгээр зугтан гарч чаджээ.

Дөчин жилийн турш цөлд төөрөн амьдарсан Израиль ард түмэн Бурханы амласан газар болох Канаан нутгийн ойролцоо Иордан голд тулан иржээ.

Израиль ард түмэн Канаан руу орохын тулд Иордан голыг гатлах хэрэгтэй болов. Завь ч байхгүй, гүүр ч байхгүй, урсгал нь маш ширүүн. Ийм үед голыг гатлана гэдэг боломжгүй зүйл байв. Тэр үед Бурхан Иошуад ингэж хэлэв.

“Би Мосетэй хамт байсан шигээ чамтай хамт байна гэдгийг тэдэнд мэдүүл! Иордан голд орж хөлөө усны захад дүр гэж гэрээний авдрыг дамнасан тахилчдад тушаа! Ингэх үед Иордан голын урсгал зогсож хуурай газар ил гарах болно.”

Гэрээний авдрыг үүрсэн тахилчид Иордан голд хөлөө дүрэв.

Тэднийг хөлөө дүрмэгц үнэхээр голын урсгал ус овоорон тогтож хуурай газар ил гарчээ.



Израилийн өвөг дээдэс улаан тэнгисийг гаталсантай адил тэд ч бас Иордан голыг ямар ч аюулгүйгээр туулан гарч чаджээ. Иерихо цайзын өмнө ирэхэд Бурхан Иошуад ингэж хэлэв.

“Та нар энэ цайзыг эзлэн авах болно.

Бүх дайчин эрс хотыг нэг удаа тойр. Үүнийг зургаан хоног хий.

Зөвхөн тахилчид эвэр бүрээ үлээх бөгөөд өөр хэн ч ямар ч чимээ гаргаж болохгүй.

Сүүлийн долоо дахь өдөр нь хотыг долоон удаа тойроод, тахилчид бүрээг үлээхэд, бүгд чангаар хашхирцгаа.

Тэр үед Иерихо цайз нуран унах болно.”

Иошуа болон Израиль ард түмэн Бурханы хэлсэнчлэн үйлдэв.

Гэтэл үнэхээр Иерихо цайз нуран унав.

Цайз нурах үед дотор нь байсан бүх хүн нурангид дарагдан амьсгал хураажээ.

Тагнуулчид амласан ёсоор Рахаб эмэгтэй болон түүний гэр бүлийг амьд үлдээв.

Бурханы үгийг дуулгавартай дагасан Иошуа болон Израиль ард түмэн амлалтын Канаан нутагт амьдрах болжээ.

- **Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Иошуа 6:20а)**

Маш чангаар уухайлсанд хана доошоо нуран унаж,



Үйл ажиллагаа 1.

Өнгийн цаасыг доорх зурган дээрхтэй адилаар хайчлан Иерихо хотыг чимэглээрэй.
(Хэрэглэгдэх материал: Өнгийн цаас, хайч, цавуу)

Жишээ зураг



